

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Авто тээврийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/002/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlhagvar@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: О.Гантуяа Утас: 70357955 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 18
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН АВТО ТЭЭВРИЙН
ТӨВИЙН ДАРГА С.ГАРЬДПҮРЭВ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн Авто тээврийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд авто машины дугаар хадгалах үйлчилгээг Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/140 тоот тушаалаар баталсан журмын дагуу хэрэгжүүлж 22,185.4 орлогыг авто тээврийн үндэсний төвийн дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Авто тээврийн төв нь улсын төсвийн хөрөнгөөр шинээр 4 дүгээр зэрэглэлийн авто буудлыг ашиглалтад оруулж, Авто тээврийн үндэсний төв төрийн өмчит үйлдвэрийн газраас, хоорондын тооцоогоор 137,297.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,632,451.88	217,633.89
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	784,047.00	0.00
1.1.06	Бараа материал	48,179,237.19	66,928,213.71
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	31,314,391.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	83,910,127.07	67,145,847.60
1.2.01	Үндсэн хөрөнгө	654,292,444.54	6,056,718,754.53
1.2.02	Биет бус хөрөнгө	193,440,000.00	193,440,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	847,732,444.54	6,250,158,754.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	931,642,571.61	6,317,304,602.13
2.1.1.01	Дансны өглөг	0.00	4,097,500.00
2.1.1.08.1	Хойшлогдсон орлого /Үндсэн хөрөнгө/	0.00	6,124,902.78
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.00	4,097,500.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0.00	4,097,500.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	34,584,792.01	34,584,792.01
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	5,355,172,618.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	897,057,779.60	917,324,789.34
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	59,137,113.16
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	897,057,779.60	858,187,676.18
2.3.11	Эздийн өмчийн дүн	931,642,571.61	6,307,082,199.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	931,642,571.61	6,311,179,699.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	736,498,139.98	866,576,467.07
02	Борлуулалтын өртөг	617,861,958.15	890,965,434.35
03	Нийт ашиг(алдагдал)	118,636,181.83	-24,388,967.28
04	Түрээсийн орлого	7,636,363.70	20,728,000.09
05	Хүүний орлого	229,628.68	476,556.31
07	Зорчигч тээврийн орлого	100,329,620.10	100,288,454.20
08	Бусад орлого	1,859,364.58	364,923.46
08.1	Орлогын дүн	110,054,977.06	121,857,934.06
10	Ерөнхий ба удирдлагын зардал	17,538,179.69	38,331,853.62
12.1	Зардлын дүн	17,538,179.69	38,331,853.62
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	211,152,979.20	59,137,113.16
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	211,152,979.20	59,137,113.16
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	211,152,979.20	59,137,113.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,681,389,713.35	1,982,249,809.93
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	180,106,230.10	186,918,682.20
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	582,197,109.85	880,791,066.65
1.1.6	Бусад мөнгөн орлого	919,086,373.40	914,540,061.08
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,678,490,622.75	1,986,141,184.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	443,782,042.49	586,523,608.41
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	60,073,841.51	77,113,323.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,802,400.00	4,229,970.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	22,300,030.00	43,271,440.20
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,662,000.00	7,088,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	20,519.52	47,655.54
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	41,546,100.00	107,771,086.53
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	1,360,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,103,303,689.23	1,158,736,100.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,899,090.60	-3,891,374.30
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	229,628.68	476,556.31
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	229,628.68	476,556.31
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,699,900.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,699,900.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,470,271.32	476,556.31
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,428,819.28	-3,414,817.99
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,203,632.60	3,632,451.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,632,451.88	217,633.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,000,000.00	0.00	918,468,113.83	923,468,113.83
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	-232,563,313.43	-232,563,313.43
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	211,152,979.20	211,152,979.20

08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	29,584,792.01	0.00	0.00	29,584,792.01
09	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	34,584,792.01	0.00	897,057,779.60	931,642,571.61
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	-38,870,103.42	-38,870,103.42
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	59,137,113.16	59,137,113.16
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	34,584,792.01	0.00	917,324,789.34	951,909,581.35

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ зөрчил илрээгүй.

Аудитаар нийт 64.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 64.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд 1 албан хаагчид 64.5 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Албан хаагчдын цалинг үнэн зөв тооцоолон олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд 1 албан хаагчийн 64,545 төгрөгийн цалинг дутуу олгосон байна.	1	64.5					1	64.5				
Дүн	1	64.5					1	64.5				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			